

## НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хүнс хангамж төв ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** НТАГ-2026/186/НА-СТА-ОНӨҮГ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Улаанбаатар хот

2026 он

Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер: Х.Түвшинбаяр

Утас:315558

Цахим хаяг: [tuvshinbayarkh@audit.gov.mn](mailto:tuvshinbayarkh@audit.gov.mn)

Аудитын менежер:

Н.Гантөгс

Утас: 315558

Цахим хаяг: [gantugsss@audit.gov.mn](mailto:gantugsss@audit.gov.mn)

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн : Azure хүлүг аудит ХХК-ийн гүйцэтгэх захирал Г.Мөнхбаяр

Утас:70110090

Цахим хаяг:[audit@azure.mn](mailto:audit@azure.mn)



ХҮНС ХАНГАМЖ ТӨВ ОНӨААТҮГ-ЫН  
ЗАХИРАЛ Д.ИДЭРЗАЯА ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54  
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026.08.13 № 510  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4, 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хүнс хангамж төв ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээг, бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Ирээдүйн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахад нөлөөлөх эргэлзээ төрүүлж байгаа нөхцөл байдал аудит хийх шалгалтын явцад материаллаг байдлын түвшинд хүрсэн алдаа зөрчил илрээгүй болно.

Тайлант онд 43.5 сая төгрөгийн ашигтай ажиллахаар баталж, гүйцэтгэлээр 184.0 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна.

Сонгинохайрхан дүүргийн төрийн өмчийн 69 цэцэрлэг, 5 сургууль, нийт 74 байгууллагад захиалгын дагуу хүнсний аюулгүй байдлын шаардлага хангасан, баталгаажсан бараа бүтээгдэхүүнийг нийлүүлж байна.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

### **Бусад асуудлын хэсэг**

Төрийн аудитын байгууллага нь санхүүгийн тайлангийн аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандартыг мөрдөж ажиллах үүрэг хүлээнэ.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 37 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг хангалттай гэж дүгнэсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлтэд бусад мэдээлэл хэсэгт тусгасан асуудал нь хамрахгүй болно.

### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

## Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	88,306,828.74	2,643,339.10
1.1.2	Дансны авлага	57,791,258.00	205,248,887.29
1.1.3	Татвар, НДШ-н авлага	73,542.20	93,666,552.13
1.1.4	Бусад авлага	5,662,969.18	3,853,650.00
1.1.6	Бараа материал	81,552,523.53	47,393,205.48
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/Тооцоо	1,289,773.09	481,221.00
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>234,676,894.74</b>	<b>353,286,855.00</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	413,921,728.11	381,115,624.87
1.2.2	Биет бус хөрөнгө	14,675,460.00	31,468,389.29
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>428,597,188.11</b>	<b>412,584,014.16</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>663,274,082.85</b>	<b>765,870,869.16</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
<b>2.1</b>	<b>Өр төлбөр</b>		
<b>2.1.1</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.1	Дансны өглөг	-	45,007,690.00
2.1.1.3	Татварын өр	95,823,252.20	40,953,809.72
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	-	4,047,235.55
<b>2.1.1.13</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>95,823,252.20</b>	<b>90,008,735.27</b>
<b>2.1.2</b>	<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	292,491.54	474,885.73
<b>2.1.2.6</b>	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>292,491.54</b>	<b>474,885.73</b>
<b>2.2</b>	<b>ӨР ТӨЛБӨРИЙН НИЙТ ДҮН</b>	<b>96,115,743.74</b>	<b>90,483,621.00</b>
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>		
2.3.1	Өмч: -Төрийн	430,498,773.30	430,498,773.30
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	14,793,440.50	21,366,634.50
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	14,675,460.00	14,675,460.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	107,190,665.31	208,846,380.36
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>567,158,339.11</b>	<b>675,387,248.16</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>663,274,082.85</b>	<b>765,870,869.16</b>

**2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>Борлуулалтын орлого /цэвэр/</b>	<b>7,911,118,253.76</b>	<b>8,136,193,336.96</b>
2	Борлуулалтын өртөг	6,900,231,403.55	6,869,129,064.12
<b>3</b>	<b>Нийт ашиг/Алдагдал/</b>	<b>1,010,886,850.21</b>	<b>1,267,064,272.84</b>
5	Хүүний орлого	630,839.91	241,143.61
8	Бусад орлого	827,272.72	2,832,272.73
9	Борлуулалт, маркетингийн зардал	337,640,095.62	486,341,363.45
10	Ерөнхий ба удирдлагын зардал	476,449,340.49	558,423,679.80
12	Бусад зардал	11,117,683.27	25,414,465.64
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз /гарз/	(20,000,000.00)	-
<b>18</b>	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг /алдагдал/</b>	<b>167,137,843.46</b>	<b>199,958,180.29</b>
19	Орлогын татварын зардал	16,279,651.87	22,519,025.17
<b>20</b>	<b>Татварын дараах ашиг /алдагдал/</b>	<b>150,858,191.59</b>	<b>177,439,155.12</b>
<b>22</b>	<b>Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/</b>	<b>150,858,191.59</b>	<b>177,439,155.12</b>
23	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	6,573,194.00
<b>24</b>	<b>Орлогын нийт дүн</b>	<b>150,858,191.59</b>	<b>184,012,349.12</b>

## 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
<b>2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>167,629,728.30</b>	<b>14,793,440.50</b>	<b>14,675,460.00</b>	<b>31,568,873.72</b>	<b>228,667,502.52</b>
Тайлант үеийн цэвэр ашиг	-	-	-	150,858,191.59	150,858,191.59
Өмчид гарсан өөрчлөлт	262,869,045.00	-	-	-	262,869,045.00
Зарласан ногдол ашиг	-	-	-	75,236,400.00	75,236,400.00
<b>2024 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>430,498,773.30</b>	<b>14,793,440.50</b>	<b>14,675,460.00</b>	<b>107,190,665.31</b>	<b>567,158,339.11</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	355,240.07	355,240.07
<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>430,498,773.30</b>	<b>14,793,440.50</b>	<b>14,675,460.00</b>	<b>106,835,425.24</b>	<b>566,803,099.04</b>
Тайлант үеийн цэвэр ашиг	-	-	-	177,440,055.12	177,440,055.12
Бусад дэлгэрэнгүй орлого	-	6,573,194.00	-	-	6,573,194.00
Зарласан ногдол ашиг	-	-	-	75,429,100.00	75,429,100.00
<b>2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>430,498,773.30</b>	<b>21,366,634.50</b>	<b>14,675,460.00</b>	<b>208,846,380.36</b>	<b>675,387,248.16</b>

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>1.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн /+/</b>	<b>8,658,688,495.54</b>	<b>8,808,437,470.71</b>
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	8,654,596,911.00	8,803,558,537.00
	Бусад мөнгөн орлого	4,091,584.54	4,878,933.71
<b>1.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн /-/</b>	<b>8,514,005,586.07</b>	<b>8,802,214,770.35</b>
	Ажиллагсад төлсөн мөнгө	449,320,072.05	617,297,789.78
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	130,280,385.52	174,094,538.37
	Бараа материал худалдан авахад төлсөн мөнгө	7,229,201,555.00	7,471,240,539.00
	Ашиглалтын зардалд төлсөн мөнгө	91,371,539.21	100,074,762.48
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө	24,758,000.00	17,968,000.00
	Татварын байгууллагад төлсөн мөнгө	533,404,303.68	369,519,767.96
	Даатгалын төлбөрт төлсөн мөнгө	540,270.00	510,624.00
	Бусад мөнгөн зарлага	55,129,460.61	51,508,748.76
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>144,682,909.47</b>	<b>6,222,700.36</b>
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
2.1	Мөнгөн орлогын дүн /+/	-	-
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
<b>2.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн /-/</b>	<b>102,780,000.00</b>	<b>24,000,000.00</b>
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө	102,780,000.00	24,000,000.00
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(102,780,000.00)</b>	<b>(24,000,000.00)</b>
<b>3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>3.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн /+/</b>	-	-
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан мөнгө	-	-
<b>3.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн /-/</b>	<b>67,712,760.00</b>	<b>67,886,190.00</b>
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-	-
	Төлсөн ногдол ашиг	67,712,760.00	67,886,190.00
<b>3.3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(67,712,760.00)</b>	<b>(67,886,190.00)</b>
<b>4</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(25,809,850.53)</b>	<b>(85,663,489.64)</b>
<b>5</b>	<b>Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>114,116,679.27</b>	<b>88,306,828.74</b>
<b>6</b>	<b>Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>88,306,828.74</b>	<b>2,643,339.10</b>

**2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	2024 он	2025 он		Төлөвлөгөөнөөс	
	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувиар
<b>Нийт орлого</b>	<b>7,912,576.4</b>	<b>11,135,353.8</b>	<b>8,139,266.8</b>	<b>2,996,087.0</b>	<b>73.1</b>
Борлуулалтын орлого	7,905,737.2	11,134,353.8	8,136,193.3	2,998,160.4	73.1
Үйл ажиллагааны бус орлого	6,839.2	1,000.0	3,073.4	(2,073.4)	307.3
<b>Нийт зардал</b>	<b>7,745,438.6</b>	<b>11,082,903.2</b>	<b>7,939,308.6</b>	<b>3,143,594.6</b>	<b>71.6</b>
ББӨ	6,900,231.4	9,832,517.4	6,869,129.1	2,963,388.3	69.9
Цалин	543,033.2	806,112.5	732,125.8	73,986.8	90.8
НДШ	66,719.7	100,764.1	92,027.2	8,736.9	91.3
Шуудан холбоо	3,506.8	5,760.0	1,355.2	4,404.8	23.5
Цахилгаан дулаан ашиглалт	7,962.6	-	-	-	-
Шатахуун	16,809.8	18,882.3	14,447.1	4,435.2	76.5
Бичиг хэрэг	4,456.4	5,398.0	4,424.1	973.9	82.0
Хангамжийн зардал	-	5,400.0	5,113.2	286.8	
Хог	480.0	480.0	480.0	-	100.0
Сэлбэгийн зардал	6,390.5	10,468.0	7,870.7	2,597.3	75.2
Хөдөлмөр хамгаалал	5,561.7	22,554.6	21,359.2	1,195.4	94.7
Ашиглалтын зардал	7,172.0	7,137.1	7,018.4	118.7	98.3
Түрээсийн зардал	62,590.0	68,868.2	55,143.8	13,724.4	80.1
Засварын зардал	20,889.6	14,300.0	11,132.6	3,167.4	77.9
Бусад зардал	14,545.9	13,570.0	12,600.1	969.9	92.9
Бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ	-	19,000.0	6,300.0	12,700.0	0.3
Шагнал урамшил	10,443.4	30,080.0	24,666.1	5,413.9	82.0
Элэгдлийн зардал	41,360.0	56,561.1	45,268.1	11,293.0	80.0
Сургалтын зардал	2,168.0	15,500.0	3,433.6	12,066.4	22.2
Албан томилолт	-	12,000.0	-	12,000.0	-
<b>Үйл ажиллагааны зардал</b>	<b>814,089.5</b>	<b>1,212,835.8</b>	<b>1,044,765.0</b>	<b>168,070.8</b>	<b>86.1</b>
Үйл ажиллагааны бус зардал	11,117.7	37,550.0	25,414.5	12,135.5	0.7
Үндсэн хөрөнгө дахин үнэлгээний нэмэгдэл	20,000.0	-	6,573.2	(6,573.2)	100.0
<b>Үйл ажиллагааны бус зардал</b>	<b>31,117.7</b>	<b>37,550.0</b>	<b>25,414.5</b>	<b>12,135.5</b>	<b>0.7</b>
<b>Татвар төлөхийн өмнөх ашиг</b>	<b>167,137.8</b>	<b>90,000.6</b>	<b>225,372.7</b>	<b>(135,372.1)</b>	<b>2.5</b>
Орлогын татварын зардал	16,279.7	9,000.1	22,519.0	(13,519.0)	2.5
<b>Цэвэр ашиг</b>	<b>150,858.2</b>	<b>43,450.5</b>	<b>184,012.3</b>	<b>(140,561.8)</b>	<b>423.5</b>
<b>Орлогын 1 төгрөгт ногдох зардал</b>	<b>1.0</b>	<b>1.0</b>	<b>1.0</b>	<b>0.0</b>	<b>1.0</b>

## Гурав. Аудитын илрүүлэлт:

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Аудитаар нийт 6,387.9 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрсэнд, 2,626.4 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж, цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 3,761.5 мянган төгрөгийн 2 зөвлөмж хүргүүлээ.

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Тайлант хугацааны эцсээрх авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.	1	2,626.4	-	-	1	2,626.4	-	-	-	-	-	-
2	Ус суваг удирдах газрын байранд сургалт зохион байгуулахдаа сургалтын заал түрээсийн гэрээ байгуулаагүй, гэрээ дүгнэсэн актыг бүрдүүлээгүй байна.	1	2,435.0	-	-	-	-	1	2,435.0	-	-	-	-
3	Бараа материалын дэлгэрэнгүй тайланд насжилт өндөртэй, үлдэгдэлд өөрчлөлт ороогүй 1.3 мянган төгрөгийн материал байна.	1	1,326.5	-	-	-	-	1	1,326.5	-	-	-	-
	<b>Дүн</b>	<b>3</b>	<b>6,387.9</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>2,626.4</b>	<b>2</b>	<b>3,761.5</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.